



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 09 сарын 12 өдөр

Дугаар 5/15

Улаанбаатар хот


Г.Бямбасайханыг ажлаас түр чөлөөж,
буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Засгийн газрын 2004 оны 112 дугаар тогтоолын хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны мэргэжилтэн Гаасүрэнгийн Бямбасайханы төрсөн эцэг Ходоодны хорт хавдар тусаж асран тэтгэх шаардлагатай байгаа тул 2018 оны 9 дүгээр сарын 12-ны өдрөөс 10 дугаар сарын 12-ны өдрийг дуустал ажлаас түр чөлөөлж, нэг удаагийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Нэг удаагийн буцалтгүй тусламж олгоход шаардагдах 110.000 /нэг зуун арван мянга/ төгрөгийг урамшуулал, тэтгэвэр, тэтгэмжийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /Л.Төгөлдөр/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.ГАНБОЛД